



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Эзэнгүй, нохой муурын тоог бууруулах,  
түр байрлуулан асрамжлах газарт хүргэх нэгдсэн  
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 1-43 хорооны нутаг дэвсгэр, зуслангийн бүсэд эзэнгүй нохой, муурыг барьж түр байрлуулан асрамжлах газарт хүргэх нэгдсэн арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн 02 дугаар сарын 13-ны өдрүүд хүртэл зохион байгуулсугай.

2.Эзэнгүй нохой, муурыг барих нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, эзэнгүй нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газарт хүргэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийг 2 дугаар, эзэнгүй нохой, муур барих нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээний хуваарийг 3 дугаар, хяналт тавихад шаардагдах шатахууны зардлын тооцоог 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Эзэнгүй нохой, муур барих нэгдсэн арга хэмжээнд шаардагдах 2,330,000 (Хоёр сая гурван зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын төсвөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан нэгдсэн удирдлагаар ханган үр дүнг тооцож ажиллахыг Дүүргийн менежер (Д.Баярсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТТӨР

9023100756  
9091904 - СБТ23271



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01 дугаар сарын 29 ны өдрийн  
А/43 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Дүүргийн менежер

Гишүүд:

Сонгинохайрхан дүүргийн  
Цагдаагийн газар

Хотын стандарт тохижилт нийтийн аж  
ахуйн хэлтсийн дарга

Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн  
дарга


Сонгинохайрхан дүүрэг дэх Мал  
эмнэлэгийн тасаг

Хороодын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Агаарын бохирдолтой тэмцэх  
тасгийн Орчны бохирдол, хог хаягдал  
хариуцсан мэргэжилтэн

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01 дугаар сарын 22-ны өдрийн  
А/02 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**ЭЗЭНГҮЙ НОХОЙ, МУУРЫГ БАРЬЖ ТҮР БАЙРЛУУЛАН АСРАМЖЛАХ ГАЗАРТ  
ХҮРГЭХ, АСРАМЖЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**1.Зорилго**

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, зорчих нөхцөлийг бүрдүүлэх зэрлэг амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, дүүргийн 43 хорооны нутаг дэвсгэрт байгаа эзэнгүй нохой, муурын тоог бууруулах, эзэнгүй нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газар хүргэж асрах, эзэнтэй болгоход удирдамжийн зорилго оршино.

**2.Хамрах хүрээ**

43 орооны нутаг дэвсгэр, зуслангийн бүс, эдэлбэр газар

**3.Зохион байгуулагч**

Дүүргийн Засаг даргын тамгын газрын Агаарын бохирдолтой тэмцэх тасаг, Цагдаагийн газар, Мал эмнэлэгийн тасаг

**4.Хугацаа:**

Эхлэх хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр  
Дуусах хугацаа: 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

**5.Нэгдсэн арга хэмжээний зохион байгуулалт**


Дүүргийн Засаг даргын захирамжаар баталсан хуваар, зураглалын дагуу эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах арга хэмжээг зохион байгуулна.

Эзэнгүй нохой, муурыг самналт байдлаар үргээж, занганд оруулж барих аргаар зохион байгуулах бөгөөд үргээх, барих ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн байгууллагын, зөвлөгөө, сургалтаар хангасан байна.

Нэгдсэн арга хэмжээний ажлын хүрээнд 43 хороод зохион байгуулалт хийж, Цагдаа, хороодын Засаг дарга, Хог хаягдлын олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч нар хариуцсан хорооны нутаг дэвсгэрт газарчилж, хяналт тавьж, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Нэгдсэн арга хэмжээний өдрүүдийн үйл ажиллагааны мэдээллийг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт өдөр бүр тайлагнаж ажиллах бөгөөд өдөр тутмын дүн мэдээг өдөр бүр 15 цагт өгнө.

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01 дугаар сарын 23 ны өдрийн  
А/43 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**ЭЗЭНГҮЙ НОХОЙ, МУУР БАРИХ, ТООГ БУУРУУЛАХ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРЧИМЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУВААРЬ**

| № | Байршил, чиглэл         | Хугацаа                 | Хамтран ажиллах байгууллага | Хариуцах эзэн  |
|---|-------------------------|-------------------------|-----------------------------|--|
| 1 | Толгойт бүсийн хороод   | 2026.01.22-02.13 хүртэл | Цагдаагийн газар            | АБТТ,<br>Хороодын засаг дарга, хэсгийн ахлагч, ХХОНБ нар |
| 2 | Баянхошуу бүсийн хороод |                         |                             |  |
| 3 | Төв, Өнөр бүсийн хороод |                         |                             |  |
| 4 | Өнөр бүсийн хороод      |                         |                             |  |

1. Дүүргийн Засаг даргын захирамжаар баталсан хуваарь, зураглалын дагуу эзэнгүй нохой, муурыг барих, тоог бууруулах арга хэмжээг зохион байгуулна.

2. Эзэнгүй нохой, муурыг самналт байдлаар үргээж, занганд оруулж барих аргаар зохион байгуулах бөгөөд үргээх, барих ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн байгууллагын, зөвлөгөө, сургалтаар хангасан байна.


3. "Мейжик тайм" ХХК 3 машинтай хуваарийн дагуу гарч ажиллах бөгөөд зуслангийн бүсүүдэд зэрлэгшсэн нохой, иргэдийн эрүүл мэндэд хор хохирол учруулж болзошгүй зэрлэгшсэн, өвчтэй нохой, муурыг газар дээр нь буудаж устгах, барьсан нохой, муурыг тээвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.

4. Нэгдсэн арга хэмжээний ажлын хүрээнд 43 хороод зохион байгуулалт хийж, хорооны цагдаа, хэсгийн байцаагч, хороодын Засаг дарга, хог хаягдлын олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч нар хариуцсан хорооны нутаг дэвсгэрт нохой, муур барих ажлыг аюулгүй байдлаа ханган зохион байгуулж, барьсан нохой муурыг Мейжик тайм ХХК-д хүлээлгэн өгнө.

5. "Мейжик тайм" ХХК хороодууд барьж өгсөн нохой, муурыг асрамжийн газарт хүлээлгэн өгч, хүлээгн өгсөн нотолгоо баримтыг илтгэх хуудсаар Агаарын бохирдолтой тэмцэх тасагт тайлагнаж ажиллана.

6. Иргэд олон нийтэд чиглэсэн сурталчилгааны ажлыг дүүргийн Хэвлэл, мэдээлэл олон нийттэй харилцах төв тогтмол зохион байгуулах

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 01 дугаар сарын 20 ны өдрийн  
А/49 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

| №        | Хэлтэс, албадын нэр              | Зардлын нэр                           | Олгох шатахууны хэмжээ (төг) | Зориулалт                   |
|----------|----------------------------------|---------------------------------------|------------------------------|-----------------------------|
| 1        | Агаарын бохирдолтой тэмцэх тасаг | Унааны зардал                         | 100,000                      | Хяналт тавих                |
| 2        | Цагдаагийн хэлтэс                | Унааны зардал                         | 200,000                      | Хяналт тавих                |
| 2        | Байр хорооллын 11 хороо          | Унааны зардал (тус бүр 30,000 төгрөг) | 330,000                      | Барих ажил зохион байгуулах |
| 3        | Гэр хорооллын 32 хороо           | Унааны зардал (тус бүр 50,000 төгрөг) | 1,600,000                    | Барих ажил зохион байгуулах |
| Нийт дүн |                                  |                                       | 2,230,000                    |                             |